



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/168

Номгон

Г Үндэсний Монгол бичгээр албан хэргийг
хөтлөх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Төрийн албан хэргийг Монгол үндэсний бичгээр хослуулан хөтөлж эхэлсэнтэй холбогдуулан Албан хэвлэмэл хуудасны эх загвар зохиох, хянаж, батлуулах, санд бүртгэх, хэвлэх, ажилтнуудыг сургаж мэргэшүүлэх ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Албан хэвлэмэл хуудасны хэвлэлт, олголт болон бусад зохион байгуулалтад арга хэмжээ авч, дэмжлэгт шаардлагатай 19.500.000 (Арван есөн сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав), Архивын тасаг, (В.Эрдэнэчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

• 625010487